



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

### Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагааг дүгнэх тухай

Боловсролын тухай хуулийн 36.12.5 дугаар заалт, Үндэсний аудитын газрын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07-904 тоот Аудитын гэрчилгээ, Боловсрол, шинжлэх ухааны яамны 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайлан, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

2. 2022 оны их сургуулийн төсөв, төлөвлөлтийн үйл ажиллагаанд чанарын ахиц гарган, санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, үргүй зардлыг бууруулан, хэмнэлттэй ажиллахыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захирал Б.Очирбатад даалгасугай.

3. Үндэсний аудитын газрын болон Боловсрол, шинжлэх ухааны яамны албан шаардлагын биелэлтийг дурдсан хугацаанд хүргүүлж, зөрчлийг арилгах болон зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг ШУТИС-ийн Удирдах зөвлөлд танилцуулахыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захирал Б.Очирбатад даалгасугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот


### Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11.3 дугаар заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.4 дүгээр заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2021 оны үйл ажиллагааны орлогын төсвийн тодотголыг нэгдүгээр, үйл ажиллагааны зарлагын төсвийн тодотголыг хоёрдугаар, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захирал Б.Очирбат, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ нарт даалгасугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

### Өмнөговь аймагт Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа сургууль байгуулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 12 дугаар зүйлийн 12.1.5, Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.2, Засгийн газрын 2020 оны 142 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллежийн харьяа сургууль байгуулах журам”-ын 2.1.8, Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Их, дээд сургуулийг “сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 321 дугаар тогтоолын 1.2 дахь хэсэг, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.7 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймагт эрчим хүч, геологи, уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургуулийг 2022-2023 оны хичээлийн жилээс шинээр байгуулахыг дэмжсүгэй.

2. Өмнөговь аймагт Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургууль шинээр байгуулахтай холбогдуулан эдийн засаг, нийгмийн нөлөөллийн болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн тооцоо, сургалт явуулах чиглэлтэй уялдуулан холбогдох судалгааг бүрэн хийж, харьяа сургууль байгуулахад шаардагдах материалыг бүрдүүлэн Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал Б.Очирбатад даалгасугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР